



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2011 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 293

Улаанбаатар хот

Сургалтын төрийн сангийн зээлээр
гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ыг үндэслэн Монгол Улсын их сургуулийн багш нарын чадавхийг дээшлүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн багш Жамсрангийн Эрдэнэбаярыг Япон Улсын Акира их сургуулийн докторантурт Ашигт малтмалын хүдэржилт, гарал үүслийн чиглэлээр 3 жилийн, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн багш Ганбатын Дариймааг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Любекийн их сургуулийн докторантурт Эмгэг судлалын чиглэлээр 3 жилийн, Монгол Улсын Боловсролын их сургуулийн багш Сүхийгийн Мөнхтуяаг Япон Улсын Акитагийн их сургуулийн докторантурт Эрдэс, түүхий эдийн хими, химийн технологийн чиглэлээр 3 жилийн, Монгол Улсын Боловсролын их сургуулийн багш Чулуунбатын Мягмаргармааг АНУ-ын Линденвүүд их сургуулийн магистрантурт Мэдээлэл зүйн боловсролын чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар суралцуулсугай.

2. Суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР